2025 оны 10 сарын 22 өдөр

№ 04410-2021/00020

Дорноговь аймаг/хот  
Даланжаргалан сум/дүүрэг

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Газрын тухай хууль, Дорноговь аймаг /нийслэл/-ийн Даланжаргалан дүүрэг /сум/ -ын **Сумын Засаг даргын захирамж 2021** оны **01** сарын **20** -ны өдрийн **04410-А/17/2021** тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж, Дорноговь аймаг/хотын Даланжаргалан сум/дүүргийн Газрын алба, газар эзэмшигчийг төлөөлж Захирал ажилтай Алтанбилэг овогтой Мөнхбат нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээнд гэрээний салшгүй хэсэг болох дараахь зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:

- 1.1. газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг;
- 1.2. газар өмчлөгчөөс газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт;
- 1.3. газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг зохих журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт;

**Хоёр. Гэрээний нөхцөл**

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ **12784605 м2**

Үүнээс:

<b>Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт</b>	<b>Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ</b>	<b>Газар эзэмших хугацаа</b>
Уурхайн газар	12784605 м2	5 жил

2.2. Газар эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн хуульд заасны дагуу газрын төлбөрийг тооцож ногдуулна.

2.3. Газрын төлбөрийг нэхэмжлэхийн дагуу Татварын албанд тушаана. Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

2.4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар эзэмших, ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг 30 хоногийн дотор шинэчлэн ногдуулна.

### **Гурав. Газар ашиглагчийн эрх, үүрэг**

- 3.1. Гэрээний нөхцлийн дагуу газрыг ашиглах;
- 3.2. Газар өмчлөгчөөс газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг гаргуулж авах;
- 3.3. Гэрээнд үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах;
- 3.4. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хуульд заасан хугацаанд нь төлөх;
- 3.5. Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;
- 3.6. Газар өмчлөгчөөс газрын ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;
- 3.7. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;
- 3.8. Газар ашиглагч нь оршин байгаа хаягаа үнэн зөв гэрээнд тусгуулна. Хаяг байршил өөрчлөгдсөн тохиолдолд газар ашиглуулагчд 10 хоногийн дотор албан бичгээр мэдэгдэнэ;

### **Дөрөв. Газар ашиглуулагчийн эрх, үүрэг**

- 4.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах;
- 4.2. Уг газрыг ашиглуулахын зэрэгцээ дараахь шаардлагыг газар ашиглагчид тавих эрхтэй. Үүнд:
  - а. Газрыг үр ашигтай зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнээс гарсан зөвлөмжийг мөрдөж ажиллах
  - б. Ашиглалтын явцад байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн бол ашиглагч өөрийн хөрөнгөөр уг элэгдэл, эдвэрэлд орсон газрыг сэргээн сайжруулах
  - в. Орчны бохирдлоос сэргийлэх арга хэмжээг газар ашиглагч өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.
  - г. Газрын тухай хууль тогтоомж, газар ашиглах гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн
  - д. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй тохиолдолд газар ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно.
- 4.3. Газрын тухай хуулийн 35.3.1.-35.3.6.-д заасан үүргээ гүйцэтгээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцалж, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;
- 4.4. Газар ашиглуулах гэрээг жил бүр дүгнэх;
- 4.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

## **Тав. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт**

5.1. Газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр газар ашиглах эрхийг шилжүүлж болно гэж шийдвэрлэнэ.

5.2. Энэхүү гэрээгээр ашиглах газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь газрын тухай хуулийн 48-р зүйлд заасан нөхцөлийг дагаж мөрдөх болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

5.3. Гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: Ашиглах эрх бүхий газраа зориулалтын дагуу ашиглаагүй болон тогтоосон төлбөрийг зохих журмын дагуу төлөөгүй тохиолдолд газар ашиглах эрхийг нь хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Мөн Зохих зөвшөөрөлгүйгээр газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар ашиглах эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

### **Зургаа. Гэрээний зөрчил, хариуцлага**

6.1. Ноцтой зөрчил:

6.1.1. Газрын төлбөрийг нэхэмжлэхийн дагуу хуулийн хугацаанд төлбөрийг төлж барагдуулаагүй.

6.1.2. Газрын зориулалтыг дур мэдэн өөрчилсөн.

6.1.3. Гэрээний үүргийн зөрчлийг арилгуулах талаар газар ашиглуулагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс үндэслэл шалтаангүй татгалзсан.

6.1.4. Хууль тогтоомж зөрчин дараах байдлаар хашаа, хайс, түр хашааг барьсан. Үүнд:

а. эдэлбэр газрын хил заагаас хэтрүүлэн барьсан хашаа, хайс, түр хашаа;

б. замын уулзварт үзэгдэх орчныг хязгаарлан хаасан хашаа, хайс, түр хашаа;

в. газар ашиглах эрх нь хүчингүй болсон эдэлбэр газрын хашаа

6.2. Хариуцлага:

6.2.1. Газар ашиглуулах гэрээг дүгнүүлээгүй, тухайн жилийн гэрээний биелэлтээр тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, зөрчил дахин давтагдсан, гэрээнд заасан ноцтой зөрчил гаргасан тохиолдолд, гэрээг нэг талын санаачлагаар цуцлах, Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.

6.2.2. Энэхүү гэрээний 6.1, 7.3-т заасан зөрчлийг гаргасан тохиолдолд албан шаардлага хүргүүлж, албан шаардлагын хугацаа өнгөрмөгц, албадан буулгалтын ажлыг гүйцэтгүүлж, ажлын хөлсний зардал, хохирлыг үл маргах журмаар газар ашиглагчаас гаргуулж төлүүлнэ.

**Долоо. Газар ашиглах эрх дуусгавар болоход тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг хэрхэх тухай тохиролцоо**

7.1. Газар ашиглагчийн газар ашиглах эрх дуусгавар болоход хуульд өөрөөр заагаагүй бол уг этгээдийн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно.

7.2. Хуулинд заасан үндэслэлээр газар ашиглах эрх дуусгавар болоход уг газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг шилжүүлэх зардлыг газар ашиглагч этгээд өөрөө хариуцна.

7.3. Хуулийн хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол тухайн шатны Засаг дарга албадан нүүлгэх ажлыг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

**Найм. Бусад зүйл**

8.1. Гэрээ нь газар ашиглагчид газрыг актаар хүлээлгэн өгч, Эрх бүхий Засаг дарга газар ашиглах эрхийг олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

8.2. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн \_\_\_\_\_(үсгээр) жилийн хугацаатай байгуулав.

8.3. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

8.4. Газар ашиглуулах гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар ашиглагч гэрээний биелэлтийг жил бүрийн 06 дугаар сарын 25-ны дотор, газар ашиглуулагч гэрээний 3 дугаар зүйлд заасан үүргийн биелэлтийг 07 дугаар сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.

**Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:**

Газар ашиглуулагч:

Утас:

---

Газар ашиглагч: **Пауэрлэнд**

Газрын байршил: **Дорноговь Даланжаргалан 1-р баг, Элдэв Алаг толгой MV-021718**

Газар ашиглагчийн хаяг: **Улаанбаатар Баянгол 17-р хороо**

Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар: **/2843129/**

Банк, дансны дугаар: ,

Харилцах утас: **99285009**

Газар ашиглагч **Пауэрлэнд** нь гэрээний нөцөлийг Газрын нэгдмэл сангийн удирлагын цахим систем /www.egazar.gov.mn/-д **2025-10-22 16:53:04** цагт зөвшөөрч, баталгаажуулав.

Энэхүү гэрээний нэг хувийг **4413004923** дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын /Journal No: 36387507

Системийн огноо/System Date: 2025-12-15 17:59:08

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5013164720	ЭФ ЭМ АЙ	1,503,284.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name ХААН БАНК	1,503,284.00 MNT	1.00
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name		
	5176120446	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР		

Гүйлгээний утга/Transaction description:

1250106819543; 5209552; 99094602

**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

\_\_\_\_\_ Он/Year (YYYY) \_\_\_\_\_ Cap/Month (MM) \_\_\_\_\_ Өдөр/Day (DD)

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын /Journal No: 36297978

Системийн огноо/System Date: 2025-12-15 17:57:42

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5013164720	ЭФ ЭМ АЙ	1,503,284.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name ХААН БАНК		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name	1,503,284.00 MNT	1.00
	5176120446	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР		

Гүйлгээний утга/Transaction description:

1250106818933; 5209552; 99094602

**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

\_\_\_\_\_ Он/Year (YYYY) \_\_\_\_\_ Cap/Month (MM) \_\_\_\_\_ Өдөр/Day (DD)

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын /Journal No: 36345598

Системийн огноо/System Date: 2025-12-15 17:58:26

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5013164720	ЭФ ЭМ АЙ	1,503,284.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name ХААН БАНК		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name	1,503,284.00 MNT	1.00
	5176120446	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР		

Гүйлгээний утга/Transaction description:

1250106819253; 5209552; 99094602

**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

\_\_\_\_\_ Он/Year (YYYY) \_\_\_\_\_ Сар/Month (MM) \_\_\_\_\_ Өдөр/Day (DD)

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын /Journal No: 36437050

Системийн огноо/System Date: 2025-12-15 17:59:54

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5013164720	ЭФ ЭМ АЙ	1,838,072.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name ХААН БАНК	1,838,072.00 MNT	1.00
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name		
	5176120446	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР		

Гүйлгээний утга/Transaction description:

1250106819808; 5209552; 99094602

**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

\_\_\_\_\_ Он/Year (YYYY) \_\_\_\_\_ Сар/Month (MM) \_\_\_\_\_ Өдөр/Day (DD)



АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 2 сарын 16 өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

Нөөц хүлээн авч, бүртгэх тухай

“Ашигт малтмалын тухай хууль”-ийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2012 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны ХХ-01-05 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсэгт 2010-2011 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” дахь 13132А тусгай зөвшөөрөлтэй талбайд ноогдох эдийн засгийн үр ашигтай бодитой (В) нөөцийг 520.49 мян.тн-оор, эдийн засгийн үр ашигтай боломжтой (С) нөөцийг 197.18 мян.тн-оор, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай бодитой (В) нөөцийг 0.77 мян.тн-оор, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай боломжтой (С) нөөцийг 655.65 мян.тн-оор, нийт эдийн засгийн үр ашигтай болон тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 1374.1 мян.тн-оор зохиогчийн тооцоолсон хувилбараар, хавсралтын дагуу хүлээн авсугай.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан нүүрсний нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Геологи, мэдээллийн тасаг (Г.Алтанхуяг)-т зөвшөөрсүгэй.

Гурав. Алагтогоогийн нүүрсний ордын тодотгол нөөцийг 13132А тусгай зөвшөөрөлтэй талбайд ноогдох бодитой (В) нөөцийг 115.76 мян.тн, С<sub>1</sub> зэргийн нөөцийг 37.62 мян.тн, нийт бодитой болон С<sub>1</sub> зэргийн (В+С<sub>1</sub>) нөөцийг 153.38 мян тн, 9517А тусгай зөвшөөрөлтэй талбайд ноогдох баттай (А) нөөцийг 38.87 мян.тн, бодитой (В) нөөцийг 143.17 мян.тн, С<sub>1</sub> зэргийн нөөцийг 106.19 мян.тн, С<sub>2</sub> зэргийн нөөцийг 57.06 мян.тн-оор нийт баттай, бодитой болон С<sub>1</sub>, С<sub>2</sub> зэргийн (А+В+ С<sub>1</sub>+С<sub>2</sub>) нөөцийг 345.29 мян тн-оор тус тус 1963 онд ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн нөөцийг хэвээр үлдээсүгэй.

Дөрөв. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсэгт 9517А тусгай зөвшөөрөлтэй талбайд ноогдох нөөцөөс олборлолтонд өртсөн баттай (А) зэргийн 38.87 мян.тн, бодитой (В) зэргийн 36.3 мян.тн нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлээс хасахыг Геологи, мэдээллийн тасаг (Г.Алтанхуяг)-т зөвшөөрсүгэй.

Тав. Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийн бодитой (В) зэргийн нөөцөд тулгуурлан, ордыг ашиглах ТЭЗҮ-г боловсруулах боломжтой гэж үзсүгэй.

Зургаа. Энэхүү дүгнэлтийн 10, 11-д заасан зүйлийг цаашдын үйл ажилгаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Пауэрлэнд” ХХК (Вилльям Жон Фостер)-д анхааруулж, заасан зүйлийг зөвшөөрсүгэй.


10 0354

Долоо. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт түүний дагуу гаргасан АМГ-ын даргын тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын өдөрт багтаан ГМТ-г хүлээлгэн өгөхийг “Пауэрлэнд” ХХК (Вилльям Жон Фостер)-д даалгасугай.

Найм. Шийдвэрийн 7-д заасан үүргийг хэрэгжүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг нь түдгэлзүүлүүлэх хүртэл арга хэмжээ авахыг “Пауэрлэнд” ХХК (Вилльям Жон Фостер)-д анхааруулсугай.

Ес. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтоогогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсэгт 2010-2011 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан боловсруулалт, түүний бүх төрлийн дээжлэлтийг геологич С.Рэнцэндорж, Б.Эрдэнэхүү, Ц.Мэндбилэг, М.Мөнхгэрэл, Л.Батцэцэг нар, өрөмдлөгийн цооногуудад каротажын ажлыг “Пауэрлэнд” ХХК, нүүрсний техникийн бүрэн шинжилгээний үр дүн, петрографийн бичиглэлийг “Эс Жи Эс” Монгол лаборатори, 1:2000, 1:5000-ны масштабын байрзүйн зураглалын ажлыг “СИ ЖИ БИ И ЭМ” ХХК хариуцах, дээрхи гүйцэтгэсэн ажлуудын үнэн бодит байдал, чанарыг хянаж гаргасан дүгнэлтийг геологич С.Бямбаа, НСХ-ийн мэргэжилтэн М.Даваадорж нар, “Пауэрлэнд” ХХК хариуцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.АРИУНБАЯР

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**  
**АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР**  
**ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

2012 оны 01 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар ХХ-01-05

Улаанбаатар  
хот

*Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсэгт 2010-2011 онуудад хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, Алаг тогоогийн нүүрсний ордод 1963 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээс тооцоологдсон нөөцөөс ашиглалтын 13132А, 9517А тоот тусгай зөвшөөрлийн талбайд орших Арынхудаг хэсэгт ноогдох нөөцийн тодотгол тооцоог хэлэлцсэн тухай*

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших 13132А, 9517А тусгай зөвшөөрөлтэй Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгой хэсэгт 2010-2011 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр геологич С.Рэнцэндорж, Б.Эрдэнэхүү, Ц.Мэндбилэг, М.Мөнхгэрэл, Л.Батцэцэг нарын боловсруулсан тайлан болон уг тайлан дахь нөөцийн тооцоонд шинжээч геологич С.Бямбаа, М.Даваадорж нарын хийсэн шинжээчийн дүгнэлтүүдийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараахь ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна:

1. 1279 га талбай бүхий Алагтолгой нэртэй 13132А, 133 га талбай бүхий Арын худаг нэртэй 9517А тоот тусгай зөвшөөрлийг анх АМГТХЭГ-ын ГУУКА-ны даргын 2005 оны 03-р сарын 30-ны өдрийн шийдвэрээр “Пауэрлэнд”ХХК-д олгосон бөгөөд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрших 13132А, 9517А тусгай зөвшөөрөлтэй Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгой хэсэгт 2010-2011 онуудад хайгуулын ажлыг гүйцэтгэж үр дүнг боловсруулан бодитой болон боломжтой (В+С) нөөцийг өгч, хайгуулын ажилд 2010 онд 141,713, 696.000 төгрөг, 2011 онд 1,028,289,860.73 төгрөг зарцуулсан байна.

2. Алагтогоогийн чулуун нүүрсний ордын Алагтолгой хэсэг нь Улаанбаатар хотоос зүүн-урагш 270 км-т, Даланжаргалан сумын төвөөс зүүн-хойш 28 км-т оршдог.

3. Нүүрсний чиглэлийн судалгааг анх 1963 онд В.В.Соловьев, В.Ц.Соловьева нарын удирдлагаар Алагтогоогийн нүүрсний орд дээр хурдавчилсан хайгуулын ажлаар эхэлсэн байдаг.

Алагтогоогийн ордын нүүрс нь чанарын хувьд сайн Г-Д маркийн нүүрсэнд хамаарагддаг. Зүүндалангийн нүүрс нь 1986-1988 онд Чойрын Геологийн экспедицийн Өмнөд Чойрын 4-р ангийн “Өмнөд Чойрын талбайд хийсэн ерөнхий ба нарийвчилсан хайгуулын ажил”-ын үед тогтоогдсон. Энэ судалгаагаар нүүрсний 3 давхарга илрүүлж нүүрсний баялагийг (P<sub>1</sub>) 0.4сая,тн-оор үнэлсэн байна.

1998-1999 онд “Монгол Алт” ХХК өөрийн хөрөнгөөр Алагтогоогийн нүүрсний ордод эрэл хайгуулын ажил хийж Алагтогоогийн нүүрсний орд нь Элдэв, Далан, Жаргалант, Алагтолгой гэсэн 4 хэсгээс бүрдсэнийг тогтоож Элдэвийн хэсэгт нарийвчилсан хайгуул, Далан Жаргалантын ордуудад эрэл үнэлгээний ажил гүйцэтгэсэн байна. Энэ ажлаар Далангийн хэсэгт бодитой нөөц 458,18мян.т, боломжит нөөц 4,69 сая.т-өөр үнэлсэн байна.

Монгол Хятадын хамтарсан “Эм Си Жи Ти” ХХК 8062Х дугаартай Далан нэртэй 225га, 9949Х дугаартай Зүүндалан нэртэй 46 га талбайнуудад 2007онд хамтарсан хөрөнгө оруулалтаар хайгуулын ажил хийж гүйцэтгэсэн.

4. 2010, 2011 оны хайгуулын ажлыг “Сапфир Гео” ХХК-иас ахлах геологич С.Рэнцэндорж, геологич Алтаншагай нар удирдан геологийн маршрут, хайгуулын малталт, баганат өрөмдлөг, цооногийн каротажийн судалгаа, сорьцлолт, гидрогеологийн, байр зүй зэрэг хээрийн судалгааны ажил, лабораторийн болон суурин боловсруулалтын ажлуудыг гүйцэтгэж ордын нүүрсний давхраасын байршлын нөхцөл, хэлбэр хэмжээ, тоо чанарын өөрчлөлтийн зүй тогтлын талаарх мэдээллийг авч, нөөцийг үйлдвэрийн зэргээр тооцох нөхцлийг бүрдүүлсэн болно. Өрөмдлөгийн ажлыг “Танан импекс” ХХК-ийн Korean rig-1, Korean rig-2, YDX-3L маркийн 3 өрмийн бригад, гидрогеологийн өрөмдлөгийн ажлыг “Танан импекс” ХХК БНСУ-д үйлдвэрлэсэн цохилтот өрмийн машин (MINI-T4) маркийн өрмийн төхөөрөмжөөр хийж гүйцэтгэсэн. Суваг малталтын ажлыг “Ашигт Сувд” ХХК Дейвүү маркийн урвуу шанагтай экскаватороор гүйцэтгэсэн. Цооногийн геофизикийн судалгааг “Монкаротаж” ХХК хийв. Топогеодезийн ажлыг “Топкад” ХХК-ий инженер техникийн ажилчид гэрээгээр тус тус гүйцэтгэжээ.

5. Алагтоогогийн чулуун нүүрсний ордын Алагтолгой хэсгийг 250-300x75 м нягтралттай хайгуулын тороор хийсэн ба нүүрсний давхраас 1-11<sup>0</sup> уналтай учир босоо цооногийн системийг сонгож, талбайн хэмжээнд 66-100 м гүнтэй, 47 ш цооногоор нийт 4565 т.м өрөмдлөг, 130 тууш км эрэл зураглалын маршрут, 17 уулын ажил, 16725.06 м<sup>3</sup>, 13 ш чөмгөн сорьцлолт, 13 ш сорьцонд техникийн шинжилгээ, нүүрсний петрографийн судалгааг 4 ш, баяжуулах шинжилгээ 7ш сорьцонд, үнсний хайлах температур, элементийн шинжилгээ, хүхрийн задлан 5 ш сорьцонд, үнсний химийн найрлага 5 ш сорьцонд тус тус хийлгэсэн байна.

6. Алагтоогогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийн нүүрс нь холимог найрлагатай кларен, дюрент кларены төрөл зонхилсон чулуун нүүрс гэжээ. Нүүрсний чанарын судалгааг иж бүрнээр хийсэн ба нүүрсний үнслэг 21-32.7%, дэгдэмхий хэсгийн хэмжээ 13.93-18.24%, ажлын чийг 3-8.22%, аналитик чийг 1.11-3.75%, ажлын илч 5195-6383 ккал/кг, шатах хэсгийн илч 8119.1-8269 ккал/кг, хүхрийн агуулаг 0.95-3.35%, чөлөөт хөөлтийн зэрэг (FSI) 0-0.25, үнсний хайлах температур 1184-1378<sup>0</sup>С, туршилтын үр дүнд Алагтолгойн хэсгийн нүүрсний баяжмалын гарц 60.56-62.3% буюу дундажаар 61.4% байгаа нь дунд зэргийн баяжигдах нүүрсэнд хамаарагдаж байна. Алагтолгойн хэсгийн хэмжээнд хаягдал бүтээгдэхүүн 7.37-15.51%, дундажаар 12.38% байна. Харин завсрын бүтээгдэхүүн 15.39-17.05%, дундажаар 16.08% байна.

Алагтоогогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийн нүүрс нь Д маркт хамаарагдаж байна.

7. Алагтоогогийн нүүрсний ордын районд доод пермийн бялхмал хурдас, дээд юрийн тунамал хурдас, дээд юра-доод цэрдийн Цагаанцав формацын бялхмал-тунамал хурдас, доод цэрдийн туфоген-тунамал хурдас, дөрөвдөгчийн эх газрын тунамал хурдас тархсан байдаг.

Доод цэрдийн нүүрс агуулагч тунамал хурдас нь хагарлын ан цаваар бялхаж гарсан хүчиллэг найрлагатай вулканитын урсацаар нийцлэгээр хучигджээ. Хучаас хурдас болж байгаа вулканитууд нь риолит, риодацит, дацит тэдгээрийн туф болон туф-брекчээс бүрдэнэ.

Хайгуулын ажлаар ордын нүүрсний геологийн нөөцийн хэмжээг 13132А талбайд ногдох бодитой болон боломжтой (В+С) зэргээр нийт 1374.42 мян.тн гэж тогтоосноос В зэргээр 521.26 мян.тн, С зэргээр 852.83 мян.тн, 9517А талбайд ногдох баттай, бодитой болон боломжтой (А+В+С) зэргээр нийт 273.23 мян.тн гэж тогтоосноос А зэргээр 23.44 мян.тн, В зэргээр 198.73 мян.тн, С зэргээр 51.06 мян.тн гэж тооцжээ.

Шинжээчид нөөцийн тооцоонд хяналтын хэмжилт, тооцоо хийж, нүүрсний нийт нөөцийг тайлангийн зохиогчдын тооцоолсон хувилбараар хүлээн авахыг санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед гишүүдийн олонхийн саналаар нөөцийг шинжээчийн санал болгосноор зохиогчдын тооцоолсон хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг зүйтэй гэж үзэв.

8. Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг олборлох үеийн техник эдийн засгийн урьдчилсан тооцоо, нүүрсний шинж чанарт тулгуурлан дараахь жишиг үзүүлэлтийг ашигласан байна. Үүнд:

- Нүүрсний давхраасын нөөц тооцох хамгийн бага зузаан	- 1.0 м
- Цэвэр нүүрсний хамгийн их үнс	- 40%
- Бохирдолт тооцох чулууны үеийн хамгийн бага зузаан	- 0.50м
- Бохирдолт тооцсон нүүрсний хамгийн их үнс	- 40%

9. Урьдчилсан ТЭЗҮ-ээр төслийн нийт хөрөнгө оруулалт 2.87 тэрбум.төгрөг байх бөгөөд үүнээс барилга байгууламж 281.24 сая.төгрөг (9.77%), машин механизм, техник тоног төхөөрөмж 2.51 тэрбум.төгрөг (87.3%), бусад 83.8 сая.төгрөг (2.9%) байна. Хөрөнгө оруулалтыг үйл ажиллагаа эхлэх эхний 1, 2 болон 4-р жилд хийх бөгөөд эхний жилд 2.68 тэрбум төгрөг, 2 дахь жилд 77.25 сая.төгрөг, ашиглалтын 4 дэх жилд 115.8 сая төгрөг байна.

ТЭЗҮ тооцсон эхний 3.2 жилд уурхай хөрөнгө оруулалтаа нөхөж ашиггүй ажиллан, дараагийн жилүүдээс эхлэн ашигтай ажиллаж нөөцийн төлбөрт 592.08 сая.төг, ашгийн татварт 257.85 сая.төг, нийтдээ улсын төсөвт 1,824.65 сая.төгрөгийн орлого оруулахаар байна.

Уурхай нь төслийн хугацаанд нийтдээ 23.68 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар байна.

10. Байгаль орчныг нөхөн сэргээх, нөлөөлөлийг бууруулах, хамгаалах, урьдчилан сэргээх зардалд 1,5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

11. Цаашид хээрийн судалгааны ажлын анхдагч материалуудыг хадгалалт хамгаалалт онцгой анхаарч ажиллах, байгаль орчны үнэлгээнүүд болон орд газрыг ашиглах ТЭЗҮ-г батлагдсан нөөцөд тулгуурлан эрх бүхий хуулийн этгээдээр үндэслэлтэй боловсруулах, орд газрыг ашиглах үед нөхөн сэргээх, нөлөөллийг бууруулах, хамгаалах, урьдчилан сэргээхэд онцгой анхаарч, Монгол улсын хууль зөвлөмж, дүрэм журмыг баримталж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчидэд анхааруулахаар тогтов.

Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гаргаж буй дараахь төслийн дагуу шийдвэр гаргахыг Ашигт малтмалын газрын даргад уламжлахаар шийдвэрлэв.

1. “Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтоогогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсэгт 2010-2011 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” дахь 13132А тусгай зөвшөөрөлтэй талбайд ноогдох эдийн засгийн үр ашигтай бодитой (В) нөөцийг 520.49 мян.тн-оор, эдийн засгийн үр ашигтай боломжтой (С) нөөцийг 197.18 мян.тн-оор, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай бодитой (В) нөөцийг 0.77 мян.тн-оор, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай боломжтой (С) нөөцийг 655.65 мян.тн-оор, нийт эдийн засгийн үр ашигтай болон тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 1374.1 мян.тн-оор зохиогчийн тооцоолсон хувилбараар, хавсралтын дагуу хүлээн авах.

2. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан нүүрсний нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Геологи, мэдээллийн тасаг (Г.Алтанхуяг)-т зөвшөөрөх.

3. Алагтоогогийн нүүрсний ордын тодотгол нөөцийг 13132А тусгай зөвшөөрөлтэй талбайд ноогдох бодитой (В) нөөцийг 115.76 мян.тн, С<sub>1</sub> зэргийн нөөцийг 37.62 мян.тн, нийт бодитой болон С<sub>1</sub> зэргийн (В+С<sub>1</sub>) нөөцийг 153.38 мян тн, 9517А тусгай зөвшөөрөлтэй талбайд ноогдох баттай (А) нөөцийг 38.87 мян.тн, бодитой (В) нөөцийг 143.17 мян.тн, С<sub>1</sub> зэргийн нөөцийг 106.19 мян.тн, С<sub>2</sub> зэргийн нөөцийг 57.06 мян.тн-оор нийт баттай, бодитой болон С<sub>1</sub>, С<sub>2</sub> зэргийн (А+В+ С<sub>1</sub>+С<sub>2</sub>) нөөцийг 345.29 мян тн-оор тус тус 1963 онд ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн нөөцийг хэвээр үлдээх.

4. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтоогогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсэгт 9517А тусгай зөвшөөрөлтэй талбайд ноогдох нөөцөөс олборлолтонд өртсөн баттай (А) зэргийн 38.87 мян.тн, бодитой (В) зэргийн 36.3 мян.тн нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлээс хасахыг Геологи, мэдээллийн тасаг (Г.Алтанхуяг)-т зөвшөөрөх.

5. Алагтоогогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийн бодитой (В) зэргийн нөөцөд тулгуурлан, ордыг ашиглах ТЭЗҮ-г боловсруулах боломжтой гэж үзэх.

6. Энэхүү дүгнэлтийн 10, 11-д заасан зүйлийг цаашдын үйл ажилгаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Пауэрлэнд” ХХК (Вилльям Жон Фостер)-д анхааруулах.

7. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлттүүнийдагуу гаргасан АМГ-ын даргын тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын өдөрт багтаан ГМТ-г хүлээлгэн өгөхийг “Пауэрлэнд” ХХК (Вилльям Жон Фостер)-д даалгах.

8. Шийдвэрийн 7-д заасан үүргийг хэрэгжүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг нь түдгэлзүүлүүлэх хүртэл арга хэмжээ авахыг “Пауэрлэнд” ХХК (Вилльям Жон Фостер)-д анхааруулах.

9. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсэгт 2010-2011 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан боловсруулалт, түүний бүх төрлийн дээжлэлийг геологич С.Рэнцэндорж, Б.Эрдэнэхүү, Ц.Мэндбилэг, М.Мөнхгэрэл, Л.Батцэцэг нар, өрөмдлөгийн цооногуудад каротажын ажлыг “Пауэрлэнд” ХХК, нүүрсний техникийн бүрэн шинжилгээний үр дүн, петрографийн бичиглэлийг “Эс Жи Эс” Монгол лаборатори, 1:2000, 1:5000-ны масштабын байрзүйн зураглалын ажлыг “СИ ЖИ БИ И ЭМ” ХХК хариуцах, дээрхи гүйцэтгэсэн ажлуудын үнэн бодит байдал, чанарыг хянаж гаргасан дүгнэлтийг геологич С.Бямбаа, НСХ-ийн мэргэжилтэн М.Даваадорж нар, “Пауэрлэнд” ХХК хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА,  
ЭБЭХЯ-НЫ ГБГ-ЫН ДАРГА



Ө.ОЮУНБААТАР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН ОРЛОГЧ ДАРГА,  
АМГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.АРИУНБАЯР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.НАРАНЦЭЦЭГ



13132А, 9517А тоот тусгай зөвшөөрлийн талбайн нооцийн нэгтгэл /нооц мян.тн/

Д/д	Нооцийн зэрэг	13132А нооц (мян.тн) 1963 он	9517А нооц (мян.тн) 1963 он	13132А, 9517А нооц (мян.тн) 1963 он	Нооцийн зэрэг	13132А эдийн засгийн хувьд ур ашигтай нооц (мян.тн) 2011 он	13132А тодорхой нохцолд үр ашигтай нооц (мян.тн) 2011 он	Нооц (мян.тн) 2011 он
1	В	115.76	106.87	222.63	В	520.49	0.77	521.26
2	(А+В)	<b>115.76</b>	<b>106.87</b>	<b>222.63</b>	С	197.18	655.65	852.83
3	С <sub>1</sub>	37.62	106.19	143.81				
4	(А+В+С <sub>1</sub> )	<b>0.00</b>	<b>213.06</b>	<b>213.06</b>				
5	С <sub>2</sub>	0.00	57.06	57.06				
6	(А+В+С <sub>1</sub> +С <sub>2</sub> )	<b>153.38</b>	<b>270.12</b>	<b>423.50</b>	(В+С)	717.67	656.42	1374.09

Д/д	Нооцийн зэрэг	Блокын дугаар (13132А) 1963 он	Блокын дугаар (13132А) 2011 он	Нооц (мян.тн)	Блокын дугаар (9517А) 1963 он	Блокын дугаар (9517А) 2011 он	Нооц (мян.тн)	9517А олборлосон нооц	9517А нийт үлдэгдэл нооц	13132А, 9517А нийт нооц (мян.тн)
1	А				А-9	10С, 15С, 16С	38.87	38.87	0	0
2	В	В-3, В-4	13С, 21С, 12С, 20С	115.76	В-4, В-3	13С, 21С, 12С, 20С	143.17	36.3	106.87	222.63
3	(А+В)			<b>115.76</b>			<b>182.04</b>	<b>75.17</b>	<b>106.87</b>	<b>222.63</b>
4	С <sub>1</sub>	С <sub>1</sub> -5	11С, 13С	37.62	С <sub>1</sub> -5, С <sub>1</sub> -10	11С, 13С, 4С, 9С, 14С	106.19		106.19	143.81
5	С <sub>2</sub>				С <sub>2</sub> -11	2С, 3С	57.06		57.06	57.06
6	(А+В+С <sub>1</sub> +С <sub>2</sub> )			<b>153.38</b>			<b>345.29</b>		<b>270.12</b>	<b>423.50</b>

5 (1995)

УУЛУУРХАЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2013 оны 4 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар 13-05-03

Улаанбаатар  
хот

*Дорноговь аймгийн Даланжаргалан  
сумын нутагт орших Алагтогоогийн  
нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг  
ил аргаар ашиглах техник-эдийн  
засгийн үндэслэлийг хэлэлцсэн тухай*

“Пауэрлэнд” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн Хүрээлэнгийн инженерүүдийн боловсруулсан Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийн уурхайг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл, Монгол улсын зөвлөх инженер Б.Эрдэнэцэцэг, Уул уурхайн мэргэшсэн инженер Э.Энх-Очир нарын хийсэн шинжээчдийн дүгнэлтийг авч хэлэлцээд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний уурхайг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг МУ-ын зөвлөх инженер Б.Пүрэвтогтох зөвлөснөөр, Монгол улсын Зөвлөх инженер доктор, дэд профессор Х.Жаргалсайхан, МУ-ын зөвлөх инженер О.Цэвэгсүрэн, МУ-ын зөвлөх инженер Я.Дэрийлаамятав, Уулын инженер, магистр Ц.Нансалмаа, Уулын инженер, магистрант О.Чинзориг, Б.Энхчулуун, Г.Чингис, Уулын инженер, магистр Б.Уранчимэг, эдийн засагч Т.Эрдэнэчулуун, Цахилгааны инженер, доктор Г.Сандагдорж нар боловсруулжээ.
2. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл нь оршил, геологийн хэсэг, уулын хэсэг, эдийн засаг гэсэн 3 хэсэг, ордын геологи, ил уурхайн ашиглалтын технологи, уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа, Алагтогоогийн нүүрсний уурхайн нээлт ба уурхайн талбайн ашиглах дараалал, уулын ажлын календарчилсан төлөвлөгөө, ашиглалтын систем, ил уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмжүүдийн сонголт, уурхайн тээвэр, өрөмдлөг тэсэлгээний ажил, овоолгын аж ахуй, уурхайн ус шүүрэлт, нүүрсний чанар, засвар техникийн үйлчилгээний дэд бүтэц, агуулахын аж ахуй, уурхайн барилга байгууламж, цахилгаан хангамж, байгаль орчны хамгаалал, уурхайн нөхөн сэргээлт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, эдийн засгийн тооцоо зэрэг 18 бүлэг, 102 хуудас бүхий тайлбар бичвэр, 11ш хавсралт зураг, 83ш хүснэгт, 7ш зураг, 3ш график бусад холбогдох материалаас бүрдэж байна.
3. ЭБМЗ-ийн 2012 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн ХХ-01-05 дугаар дүгнэлт, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын 2012 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн дугаар 93 тушаалаар “Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсэгт 2010-2011 онуудад гүйцэтгэсэн эрэл-үнэлгээ, нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайлан”

13132А тусгай зөвшөөрөлтэй талбайд ноогдох эдийн засгийн ашигтай бодитой (В) нөөцийг 520.49 мян.тн-оор, эдийн засгийн боломжтой (С) нөөцийг 197.18 мян.тн-оор, тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай бодитой (В) нөөцийг 0.77 мян.тн-оор, тодорхой нөхцөлд эдийн засгийн боломжтой (С) нөөцийг 655.65 мян.тн-оор, нийт эдийн засгийн үр ашигтай болон тодорхой нөхцөлд үр ашигтай бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 1374.1 мян.тн-оор хүлээн авсан ба техник, эдийн засгийн үндэслэлийг тогтоосон нүүрсний Бодитой нөөцөд тулгуурлан боловсруулах боломжтой гэж үзсэн байна.

4. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ил уурхайн хил хязгаар доторхи геологийн нөөц 610.77 мян.тн-оос технологийн болон ашиглалтын хаягдлыг 5.61%, чулуулгийн бохирдлыг 3.27%-иар тооцож, 596.52 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн байна. Тус ордыг жилд 100.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтайгаар 6 жил ашиглахаар тооцжээ.
5. Алагтолгойн уурхайн нүүрсний давхаргын тогтоц, хөрсний зузаан, хөрсний чулуулгийн хатуулаг болон бусад уул-техникийн нөхцөлөөс хамааруулан уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг экскаватор-автосамосвалын хослол бүхий тээвэртэй ашиглалтын систем сонгон төсөлд тусгасан байна.
6. Өрөмдлөгийн ажилд KQG-120Y маркын өрмийн машин, хөрс хуулалт, элс олборлолтонд урвуу утгуурт Hyundai R210LC-7 маркын экскаватор, хөрс тээвэрлэлтэнд Foton маркын автосамосвал, нүүрсний тээвэрт Howo маркын автосамосвал, овоолгын хөрс түрэлтэнд Shantui PY-200 маркын грейдер гэх мэт тоног төхөөрөмжүүд ажиллуулахаар тооцоолсон байна.
7. Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын стандартын дагуу гүйцэтгэж техникийн нөхөн сэргээлтэнд 832.61 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтэнд 181.53 сая төгрөг зарцуулахаар тооцжээ. Нөхөн сэргээгдэж байгаа явцын мониторингийн ажлын зардалд 30 сая.төг, байгаль орчныг нөхөн сэргээлтийн ажлын нийт зардалд 1733.62 сая төг байхаар тусгасан байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хэрэгжилтэнд анхаарч ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.
8. ТЭЗҮ-ийг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулсан ба хуулийн заалт тус бүрийн дагуу эдийн засгийн тооцооллыг үнэн зөв, нарийвчлал сайтай тооцож хийсэн байна.
9. Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 3737.78 сая төг, төсөлд ашиглалтын хугацаанд борлуулалтын нийт орлого 19685.16 сая төг, ашиглалтын зардал 13853.51 сая.төгрөг, улс, орон нутгийн төсөвт оруулах нийт татвар, хураамж 4226.4 сая төгрөг, аж ахуй нэгжийн орлогын албан татвар 583.16 сая.төг, АМНАТ 492.13 сая. төгрөг төлөвлөсөн байна.
10. Төсөл хэрэгжсэнээр шууд 57 ажлын байр бий болох ба сарын дундаж цалин 882.4 мян.төгрөг байхаар төсөлд тусгасан байна.


11. Төсөлд 1тн нүүрс борлуулах үнийг 33000 төг/тн байхаар тооцоолсон байна. Татварын дараах цэвэр ашиг нь 5248.48 сая.төг байхаар тооцжээ.
12. Төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнийг 12 хувийн дискаунттайгаар бодоход 598.8 сая.төг, боломжит дотоод өгөөжийн хувь /норм/ нь MIRR=18.6% байна. Хөрөнгө оруулалтаа 3 дахь жилдээ нөхөхөөр байна.
13. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар холбогдох байгууллагууд болон орон нутагтай хамтран ажиллаж байхыг заан тэмдэглэж эрсдэлээ багасгаж ажлахыг ЭБМЗ-өөс анхааруулж байна.
14. ТЭЗҮ нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанар сайтай боловсруулагдсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, цаашид хэрхэн ашиглаж олборлох, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.
15. Энэхүү техник эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчдийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтоогогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах MV-013132A, 9517A тоот тусгай зөвшөөрөлтэй нүүрсний ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авав.
2. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон комисс уурхайг хүлээн авсны дараа уг уурхайг энэхүү ТЭЗҮ-ийн дагуу ажиллуулж эхлэхийг “Пауэрлэнд” ХХК (Брэтт Коллинс)-д анхааруулах.
3. Техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу жил бүр уулын ажлын төлөвлөгөөг боловсруулж зохих газраар хянуулах, холбогдох бусад зөвшөөрлийг эрх бүхий бусад хуулийн этгээдээс авахыг “Пауэрлэнд” ХХК (Брэтт Коллинс)-д даалгах, уулын ажлын төлөвлөгөөний дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгохыг Нүүрсний хэлтэс (Б.Алтсүх)-т зөвшөөрөх.
4. ЭБМЗ-ийн 2012 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн хуралдааны 13-05-03 дугаар дүгнэлтийн 7,13-д заасныг хэрэгжүүлж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулж, байгаль орчны төлөвлөгөөний хэрэгжилт, зардалд хяналт тавьж ажиллахыг Нүүрсний хэлтэс (Б.Алтсүх)-т тус тус даалгах.

5. Техник, эдийн засгийн үндэслэлийг бичвэр, дискийн хамт ЭБМЗ-ийн дүгнэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан Геологи мэдээллийн төвд хүлээлгэн өгөхийг “Пауэрлэнд” ХХК (Брэтт Коллинс)-д даалгах.
6. Шийдвэрийн 5-д заасан үүргийг хэрэгжүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг нь түдгэлзүүлүүлэх хүртэл арга хэмжээ авахыг “Пауэрлэнд” ХХК (Брэтт Коллинс)-д анхааруулах.
7. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг “Пауэрлэнд” ХХК (Брэтт Коллинс)-д Нүүрсний хэлтэс (Б.Алтсүх)-т тус тус даалгах.
8. “Пауэрлэнд” ХХК-ий захиалгаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэл нь оршил, ордын геологи, ил уурхайн ашиглалтын технологи, уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа, Алагтогоогийн нүүрсний уурхайн нээлт ба уурхайн талбайн ашиглах дараалал, уулын ажлын календарчилсан төлөвлөгөө, ашиглалтын систем, ил уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмжүүдийн сонголт, уурхайн тээвэр, өрөмдлөг тэсэлгээний ажил, овоолгын аж ахуй, уурхайн ус шүүрэлт, нүүрсний чанар, засвар техникийн үйлчилгээний дэд бүтэц, агуулахын аж ахуй, уурхайн барилга байгууламж, цахилгаан хангамж, байгаль орчны хамгаалал, уурхайн нөхөн сэргээлт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, эдийн засгийн тооцоог боловсруулсан Уул уурхайн Хүрээлэн хариуцах, түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч Монгол улсын зөвлөх инженер Б.Эрдэнэцэцэг, Уул уурхайн мэргэшсэн инженер Э.Энх-Очир нарын хийсэн нар хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
 ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, УУЯ-НЫ  
 СТРАТЕГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
 ГАЗРЫН ДАРГА  Ч.ОТГОЧУЛУУ

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
 ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ ДАРГА,  
 УУЯ-НЫ УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН  
 ХЭЛТСИЙН ДАРГА  Б.НЭРГҮЙ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Д.ХАНГАЙ



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 7/110.

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл  
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, "Ашигт малтмалын тухай хууль"-ийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн т/18-10-13 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших "Пауэрлэнд" ХХК-ийн MV-013132 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Алагтоогогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол (I)-ыг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Нүүрсний судалгааны хэлтэс (М.Мэндбаяр)-т зөвшөөрсүгэй.

3. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Нүүрсний судалгааны хэлтэс (М.Мэндбаяр)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Нүүрсний судалгааны хэлтэс (М.Мэндбаяр)-т даалгасугай.

5. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших "Пауэрлэнд" ХХК-ийн MV-013132 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Алагтоогогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол (I)-ыг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг "Пауэрлэнд" ХХК-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

10 1315



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДҮГНЭЛТ

2018 оны 08 сарын 16 өдөр

Дугаар Т/18-10-13

Улаанбаатар хот

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших MV-013132 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол-1/-г хэлэлцсэн тухай

“Пауэрлэнд” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Эрдэнэс инженеринг” ХХК боловсруулсан Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгой хэсгийг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол-1/-д уул уурхайн мэргэшсэн инженер Б.Баяраа зөвлөж, уулын инженер Монголын улсын зөвлөх инженер С.Дэлгэрдалай, уулын инженер Н.Даваасүрэн, GIS инженер Б.Алтанзагас нар боловсруулж, Монгол Улсын зөвлөх инженер З.Төмөрбаатар шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Техник-эдийн засгийн үндэслэл нь Геологийн хэсэг, Ил уурхайн олборлолт, Уурхайн дэд бүтэц, Нүүрсний чанар, Уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн ажлын технологи, Эдийн засгийн үр ашиг зэрэг 7 бүлэг, дүгнэлт, хавсралт материал, хавсралт тооцоо бүхий 122 хуудас тайлбар бичиг, 28 ш хавсралт зургуудаас бүрдэж байна.

2. Алагтогоогийн нүүрсний ордын Алагтолгойн хэсгийн MV-013132 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2012 оны 01 дугаар сарын 11-ны өдрийн хурлын ХХ-01-05 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2012 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 93 дугаар тушаалаар чулуун нүүрсний ордын эдийн засгийн хувьд үр ашигтай В зэргийн нөөц 520.5 мян.тн, С зэргийн нөөц 197.18 мян.тн, нийт (В+С) 717.67 мян.тн мөн тодорхой нөхцөлд үр ашигтай В зэргийн нөөц 0.77 мян.тн, С зэргийн нөөц 655.65 мян.тн, нийт (В+С) 656.42 мян.тн, нийт эдийн засгийн үр ашигтай болон тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 1374.1 мян.тн-оор ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

3. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 4.57% (84091.1тн), бохирдлыг 2.65%-аар (42449.4тн) авч тооцсон ба ордыг 4 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 3709.13 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, магадласан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн хүдрээр 641.86 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал 200.0 мян.тн.

000759

4. Алагтогоогийн нүүрсний уурхайн Алагтолгой хэсгийг ашиглахад эдийн засгийн үр ашигтай нөөцөд тулгуурлан 1тн нүүрсний үнэ 83.6 мян.төг-өөр борлуулах эдийн засгийн тооцоог хийж ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулсан байна.

5. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг олборлолтын нөхцөл, уурхайн хэмжээ, жилд хийгдэх нийт уулын цулын эзлэхүүн зэргээс хамаарч хөрс хуулалт, болон олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээ – экскавацлалт – автосамосвал – гадаад овоолго гэсэн ил уурхайн автотээвэртэй ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ. (Жилийн хүчин чадал нь 200.0 мян.тн)

6. Тус уурхайд KGQ маркийн өрмийн машин 1ш, SD23 маркийн бульдозер 1ш, Hyundai R210LC-7 маркийн экскаватор 3ш, 25 тн даацтай Howo автосамосвал 3ш, ZL-50 маркийн утгуурт ачигч 1ш, гадаад тээвэрт 40 тн даацтай Howo маркийн автосамосвал 2ш зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар ТЭЗҮ-н тодотголд тусгажээ.

